

МОНГОЛ УЛСААС ARF, ASEM, ACD-Д ОРОЛЦОХ БОДЛОГЫН ТУХАЙД

Д.Баярхүү

Монгол-Вьетнамын хоёр талын харилцаа олон улсын ба бүс нутгийн олон талт үйл явц, форумын хүрээнд идэвхтэй өрнөж ирснийг юуны өмнө тэмдэглэе. БНСВУ нь 1995 онд АСЕАН-д элссэнээр Монгол Улс Зүүн өмнөд Азийн олон талт хамтын ажиллагаанд оролцох нэгэн чухал боломж нээгдсэн юм.

Нэг. АСЕАН-ы Бүсийн чуулга – АРФ

Монгол Улс АСЕАН-ы бүс нутгийн олон талт үйл явцад хоёр чиглэлээр оролцохыг чухалчилж үзэж байна. Энэ нь:

1. АСЕАН-ы Бүсийн чуулга буюу товчилсон нэрээр АРФ
2. “АСЕАН+Гурав” хамтын ажиллагааны үйл явц

Монгол Улс 1998 оноос гишүүнээр нь ажиллаж буй АРФ дахь үүргээ хэрэгжүүлэхдээ бүс нутгийн энэ чухал форумыг дараахи байдлаар дүтнэн үзэж байна. Үүнд:

- *Нэмэгдэл бололцоо*: Бүс нутгийн аюулгүй байдлын олон талт яриа хэлэлцээнд нэгдэн орох нь хоёр талын болон олон улсын механизмын зэрэгцээ Монгол Улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах нэмэгдмэл бололцоо олгоно гэж үзэж байна

- *Манай өөрийн бүс нутгийн аюулгүй байдлыг хэлэлцэх нэгэн суваг*: Зүүн хойд Азийн салбар бүс нутагт аюулгүй байдлын албан ёсны суваг бүрдэн хөгжөөгүй нөхцөлд энэ салбар бүс нутгийн аюулгүй байдлыг хэлэлцэх нэгэн чухал суваг болно

- *Институционал холболт*: АРФ-т нэгдсэнээр Монгол Улсын бүс нутаг дахь улс төрийн изоляцийг гэтлэн давах, манай улсыг Ази-Номхон далайн бүс нутагтай холбох нэгэн институционал суваг, бүс нутаг дахь түнш холбоотны тоог нэмэгдүүлэх бололцоо, стратегийн хамтын нийгэмлэгийн бүрэлдэхүүн хэсэг болох бололцоо нээж байна

- *Тогтвортой байдлыг хангах механизм*: Ашиг сонирхлын ялгаа бүхий орнуудыг нэгтгэсэн үйл явц болохынхоо хувьд АРФ нь олон талт хүчин чармайлтаар тогтвортой байдлыг сахин хамгаалах нэгэн механизм юм

- *Аюулгүй байдлын төсөөллуудийг мэдрэх суваг*: Үе шатлалыг эрхэмлэсэн АРФ-ын аядуу хандлагыг аюулгүй байдлын тодорхой бүс

*Д.Баярхүү - ГХЯ-ны Бодлого төлөвлөлт, мэдээлэл үнэлгээний газрын зөвлөх

өнөөгийн орчинд аюулгүй байдлын асуудлаархи улс орнуудын төсөөллүүдийг илүү сайн мэдрэх бололцоо олгох суваг гэж үзнэ

- *Бус нутгийн олон талт контекст нь хамтын ажиллагааг эрхэмлэсэн гадаад бодлогын соёл (cooperative foreign policy culture) төлөвшихөд тулхэц өгөх нэгэн боломж юм.* Монгол бол НҮБ зэрэг олон улсын байгууллагын хүрээнд аюулгүй байдлын асуудлаар экспертиз хуримтлуулсан орон. Харин АРФ-ын хэлбэр нь Монголын хувьд нэгэн шинэ хэлбэр юм. Монгол Улс АРФ-ын хүрээнд ажиллахдаа зөвшилцөл, хамтын ажиллагааг эрхэмлэсэн гадаад бодлого, үйл ажиллагааны туршлагыг бүрдүүлэх учиртай гэж үзнэ.

- *Харилцан нөхөх механизм:* Өнөөгийн шатанд АРФ-ын олон талт үйл явц нь аюулгүй байдлын хоёр талт тохиролцоонуудыг орлохгүй, гагцхүү тэдгээрийг нөхөх механизм юм. Аюулгүй байдлын асуудлаархи хоёр талын яриа хэлэлцээ, зөвлөлдөөнүүд нь олон талт үйл явцад түшиг болно гэж үзнэ

- *Мөргөлдөөнийг шийдвэрлэх чадавхи:* АРФ-ын үйл явц хэтдээ мөргөлдөөнийг шийдвэрлэх бүс нутгийн нэгэн механизм хэлбэрээр хөгжихийг дэмжинэ. Харин ийм чиглэлээр хөгжих хөрс суурь үүсч чадах эсэхийг оролцооны явцад тодорхойлох ба өнөөгийн шатанд шат дарааллыг эрхэмлэсэн аядуу хандлагыг дэмжиж, бүс нутгийн хэмжээнд мөргөлдөөнөөс зайлсхийх, маргааныг хүч үл хэрэглэн, энхийн аргаар зохицуулахад чиглэгдсэн норм хөгжүүлэн төлөвшүүлэхэд хүчин зүтгэнэ.

Зүүн өмнөд Ази – Зүүн хойд Азийн хооронд Зүүн Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа өрнүүлэх шинэхэн механизм бол “АСЕАН+Гурав” үйл явц юм. Энэ үйл явц 1997 онд Куала -Лумпурт АСЕАН-ы дээд хэмжээний хоёр дахь албан бус уулзалтын үед эхлэлээ тавьсан. Тэр үед АСЕАН-ы 10 улсын төр засгийн дээд хэмжээний уулзалтад БНХАУ, Япон, БНСУ-ын удирдагчдыг урьж оролцуулсан, мөн тусдаа “АСЕАН+1” /БНХАУ/ уулзалт зохион байгуулжээ. 1999 онд Манилад АСЕАН-ы дээд хэмжээний гурав дахь албан бус уулзалтаас “Зүүн Азийн хамтын ажиллагааны хамтарсан мэдэгдэл” гаргажээ.

“АСЕАН+Гурав” үйл явц эхэлснээс хойшхи 7 жилийн хугацаанд олон чухал санал санаачилга дэвшүүлж, хэрэгжүүлэх чиглэлээр үлэмж ажил хийгдэж байна. Зүүн Азийн ирээдүйг төсөөлөх ажлын хэсэг БНСУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар байгуулагдаж улс тус бүрээс 2 эрдэмтэн судлаач ажиллаж, Зүүн Азийн Худалдааны чөлөөт орон зай бий болгож, худалдааг либералчлах чиглэлээр санал боловсруулж байна. Японы Ерөнхий сайдын дэвшүүлсэн Зүүн Азийн хөгжлийн санаачилга Гадаад хэргийн сайд нарын болон Хөгжлийн хамтын

ажиллагааны сайд нарын дэмжлэг хүлээсэн. “АСЕАН+Гурав” үйл явцын хүрээнд Япон, БНХАУ, БНСУ нь гурван талын хамтын ажиллагаа явуулах тухай хамтарсан тунхаглал 2003 онд гаргаж, түүний хүрээнд шинэ зууны хамтын ажиллагааг эхлүүлэв.

“АСЕАН+Гурав” үйл явцын талаархи Монгол Улсын байр суурь бол:

- Бүс нутгийн энэхүү эрчимтэй хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж, хамтран ажиллахад бэлэн байна. Учир нь бүс нутгийн байршил, хоёр талын хамтын ажиллагааны байдал, Монголд хандивлагч орнуудын оролцоог авч үзвэл Монгол Улс нь “АСЕАН+Гурав” үйл явцын гадна үлдэх учиргүй.

- 1997 онд бүс нутгийн орнуудын эдийн засагт хүчтэй нөлөөлсөн Азийн санхүүгийн хямралын дараа шинэ хямралаас сэрэмжлэх үүднээс бүс нутгийн орнуудын эдийн засаг-санхүүгийн хамтын ажиллагаагаа уялдуулан зохицуулж байгааг Монгол Улс бүрэн дэмжиж байна.

- Цаашдаа Монгол Улс Зүүн Азийн эдийн засгийн нэгдсэн орон зайд хамрагдах, улмаар АПЭЖ-т элсэхэд “АСЕАН+Гурав” механизм томхон дэмжлэг болно гэж үзэж байна.

Хоёр. АСЕМ – Ази-Европын уулзалт

Ази-Европын дээд хэмжээний уулзалт хийх санаачилгыг анх 1994 онд Сингапурын Ерөнхий сайд Го Чок Тонг Францад айлчлах үеэрээ гаргасан. АСЕМ нь Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой “АСЕАН+ЕХ+Гурав” үйл явц бөгөөд одоогийн байдлаар энэ үйл явцыг батламжилсан ямар нэг гэрээ хэлэлцээр байхгүй, байнгын ажиллагаатай зохион байгуулалтын бүтэцгүй, өөрийн гэсэн санхүүгийн эх үүсвэргүй.

АСЕМ-ийн үндсэн зорилго нь дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх болон эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн таатай нөхцлийг бүрдүүлэх үүднээс Ази, Европын хэлхээ холбоог бэхжүүлэхэд оршиж байна.

Эдүгээ АСЕМ нь Ази, Европыг холбосон харилцааны нэг гол суваг, стратегийн хувьд Атлантын нөгөө талын хэт давамгайллыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн олон улсын харилцааны томхон механизм болжээ. Уг үйл явцын хүрээ өргөжихийн хэрээр дэлхийн улс төрт үзүүлэх жин нөлөө нь өсч, АСЕМ-ийн гишүүн улс орнууд улс төр, аюулгүй байдал, худалдаа, эдийн засгийн асуудлаар идэвхтэй яриа хэлэлцээ өрнүүлж байна.

“Ази-Европын хамтын ажиллагааны Тохиролцоо”, “Олон улсын терроризмын эсрэг хамтран ажиллах тухай Копенхагены тунхаглал”, “Солонгосын хойгт энх тайвныг бэхжүүлэх тухай Копенхагены улс төрийн тунхаглал”, “Үй олноор хөнөөх зэвсэг болон түүнийг тээгч хэрэгслийг үл дэлгэрүүлэх тухай улс төрийн тунхаглал” зэрэг улс төрийн чухал баримт бичгүүд батлан гаргажээ. АСЕМ-ийн дээд хэмжээний болон Гадаад хэргийн сайд нарын уулзалтуудаар олон улсын асуудлаар байр сууриа тогтмол илэрхийлдэг уламжлал тогтоож, соёл-хүмүүнлэгийн салбарт Ази-Европын “хамтын үнэт зүйлс” бий болгох чиглэлээр ажиллаж байна.

АСЕМ нь нэгэнтээ Ази-Европын түншлэлийг бэхжүүлэх зорилготой нээлтэй, хувьсан хөгжих үйл явц бөгөөд гишүүнчлэлээр эгнээгээ өргөжүүлэх асуудлыг үе шаттайгаар, гишүүнээр элсэхийг хүссэн орнуудын үйл ажиллагаа, АСЕМ-ын үйл явцад оруулах хувь нэмрийг нь харгалзан шийдвэрлэх дүрэмтэй. Гишүүнээр элсүүлэх тухай шийдвэрийг гишүүнээр элсэхийг хүссэн орон өөрийн тивийн орнуудын дэмжлэгийг авсны дараа нийт гишүүн орнууд консенсусын зарчимд тулгуурлан шийдвэрлэнэ. Энэ талаарх эцсийн шийдвэрийг АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтаар гаргана.

Гишүүн элсүүлэх тухай яриа хэлэлцээний явц, төлөв гишүүн орнуудын байр суурь зөрүүтэйн улмаас өнөөг хүртэл тохиролцоонд хүрч чадаагүй байна. 1996 оноос хойш Энэтхэг, Пакистан, Австрали, Шинэ Зеланд, Бангладеш, ОХУ, Норвеги, Швейцари зэрэг нийтдээ 20 гаруй улс АСЕМ-д элсэх хүсэлтээ ямар нэг байдлаар илэрхийлсний дотроос АСЕАН-ы гишүүн Лаос, Камбож, Европын Холбооны шинэ 10 улс тив, тивийн орнуудынхаа дэмжлэгийг хүлээсэн.

АСЕМ-д шинээр гишүүн элсүүлэх асуудал нээлттэй боловч шинээр гишүүн элсүүлэх асуудлаар янз бүрийн болгоомжлол байдаг. Тухайлбал үндэсний ба олон улсын элдэв бэрхшээл дагуулсан улсаар АСЕМ нь дүүрвэл үйл ажиллагаанд нь тодорхой бэрхшээл үүсч, цаашид төвлөрсөн байдлаар асуудлыг хэлэлцэхэд саад тотгор болж болзошгүй гэсэн болгоомжлол байна. Мөн нарийн бичгийн дарга нарын газар байхгүй өнөөгийн нөхцөлд гишүүдийг тоог нэмэх нь АСЕМ ажлын баримжаагаа алдахад хүргэж болзошгүй гэсэн тооцоо бий.

Монгол Улсын тухайд АСЕМ-д оролцох зорилгоор хоёр талын шугамаар үргэлжлүүлэн ажилласаар ирсэн бөгөөд дараахи бодлого, чармайлтыг өмнөө тавьж байна. Үүнд:

- Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх

зорилготой АСЕМ-д гишүүнээр элсэн, үйл ажиллагаанд оролцох нь Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн интеграци, хамтын ажиллагааны олон талт механизмд зохистой хэлбэрээр оролцохыг зорьж байдаг манай улсын эрх ашигт нийцнэ.

- АСЕМ-д элсэх нь олон талт яриа хэлэлцээнд оролцох шинэ суваг болох үүднээс бүс нутаг дахь манай улсын байр суурийг бэхжүүлэх ач холбогдолтой төдийгүй АСЕМ-ын хүрээнд хэрэгжих өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн худалдаа, эдийн засаг, соёл боловсролын чиглэлээрх төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой болох юм.

- Гишүүнээр элсэхийг хүссэн улс юуны өмнө өөрийн тивийн орнуудын дэмжлэг авдаг зарчмын дагуу манай тал эхний ээлжинд Зүүн хойд Азийн орнуудын зохицуулагч Япон, Зүүн өмнөд Азийн орнуудын зохицуулагч Вьетнам болон АСЕМ-ын гишүүн Азийн бүх орнуудаас дэмжлэг хүсээд байна. Монгол Улсын Ерөнхий сайдаас БНСВУ-ын Ерөнхий сайдад хандаж дэмжлэг хүссэн захидал илгээсний сацуу Гадаад хэргийн сайдаас АСЕМ-ын гишүүн Азийн бүх улс орны Гадаад хэргийн сайд нарт захидал илгээснээс БНСВУ, БНСУ, БНХАУ-аас манай хүсэлтийг дэмжсэн хариу захидал ирүүлсэн.

- Азийн орнууд тивээсээ эхний ээлжинд Лаос, Камбож, Мьянмаг элсүүлэх байр суурин дээр хатуу зогсож, харин Европын орнууд Мьянмаг элсүүлэх дээр эргэлзэж энэ гурван улсыг багцаар нь элсүүлэхийг эсэргүүцэн Мьянмаг үлдээсэн бөгөөд үүнийг тойрсон санал зөрөлдөөн намжаагүй байна. Ийм нөхцөлд манай улсыг АСЕМ-д элсэхэд ямар нэг хэмжээгээр саад тогтор учирч болзошгүй гэж үзэж байна.

- Манай талын захидалд одоогоор хариу ирүүлээгүй байгаа Азийн 7 орон - Япон, Малайз, Бруней, Тайланд, Филиппин, Индонез, Сингапурын дэмжлэгийг юуны өмнө бичгээр авах чармайлтаа сулруулахгүй.

Гурав. АСД – Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ

Ази тивд “Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ (АХАЯХ буюу Asia Cooperation Dialogue) хэмээх нэгэн хамтын ажиллагааны механизм үүсгэн бий болгох санаачилгыг анх Тайландын эрх баригч намын дэд дарга, Гадаад хэргийн сайд 2000 онд Манилад болсон “Азийн улс төрийн намуудын анхдугаар олон улсын бага хурал” дээр Тайландын Ерөнхий сайдын нэрийн өмнөөс дэвшүүлэн тавьж, залгуулаад 2001 онд АСЕАН-ы Гадаад хэргийн сайд нарын ээлжит уулзалтад Тайландын тал “Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ”-ний механизм бий болгохыг албан ёсоор санал болгосон түүхтэй.

Тайландын тал Азийн олон улс орны төр, засгийн тэргүүн нар, улс төрчид, судлаачидтай санал солилцож, тэдгээрийн өргөн дэмжлэгийг авсны үр дүнд 2002, 2003 онд Гадаад хэргийн сайд нарын хоёр уулзалтыг зохион байгуулж анхдугаар уулзалтад АСЕАН-ы гишүүн 10 орон, БНХАУ, Япон, БНСУ, Азийн бусад хэсгээс Энэтхэг, Пакистан, Бангладеш, Бахрейн, Катар зэрэг 18 улс оролцож, хоёр дахь уулзалтын үеэр Казахстан, Кувейт, Оман, Шри Ланка, 2004 оны гурав дахь уулзалтаар Монгол Улс нэмэгдэж гишүүнээр элсээд байна. АХАЯХ-нд Монгол Улсыг элсэхэд дэмжлэг хүсч манай Гадаад хэргийн сайдаас АХАЯХ-ний гишүүн орнуудад захидал илгээж мөрөөр нь ажилласан бөгөөд Мьянма, Сингапур Камбож, Япон, Вьетнам, Казахстан, Хятад, Тайланд, Энэтхэгийн Гадаад хэргийн сайд нар дэмжсэн хариу ирүүлсэн юм.

Монгол Улсын тухайд АХАЯХ-нд оролцоходоо дараахи бодлого, чармайлтыг өмнөө тавьж байна. Үүнд:

- Ази тивийн бараг бүхий л салбар бүс нутагт улс төр, эдийн засаг, худалдааны бүлэглэл, яриа хэлцээний механизмууд үүсээд буй боловч Ази тивийг бүхэлд нь хамарсан, тивийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэх механизм дутагдаж байгаа үед АХАЯХ чухал ач холбогдолтой шинэ форум юм

- Ази тив хэдийгээр том, эдийн засгийн хөгжлийн нөөц чадавхи сайтай ч даяаршил, харилцан хамаарлын өнөө үед өөр хоорондоо нягт хамтын ажиллагаа өрнүүлж чадаагүйгээс дэлхийн эдийн засгийн аливаа өөрчлөлт, санхүүгийн зах зээлийн өөрчлөмтгий байдалд өртсөөр байгаа үед Азийн орнуудын хооронд хандивлагч, хүлээн авагчийн харилцаа бий болгоход бус, бие биенээ нөхсөн хамтын ажиллагааны шинэ хэлбэр бий болгоход чухал ач холбогдолтой

- АНУ, Европын Холбооны зүгээс АХАЯХ-ний үйл явцыг ихээхэн сонирхож байгаа нь олон улсын зүгээс хүчтэй дэмжлэг хүлээх гол нөхцөл болж байна. Энэ утгаараа АСЕМ-аас дутахгүй бүс нутгийн яриа хэлэлцээний томхон механизм төлөвшиж байж болзошгүй.

- Төслийн хамтын ажиллагаануудад Монгол Улс бололцооны хэрээр оролцохыг зорьж ажиллана. Тухайлбал АХАЯХ-ний гишүүн 14 улс хамтын ажиллагааны 17 салбарт сайн дураар “хошуучлагч” /prime-movers/ болохоо мэдэгдсэн нь:

1. Эрчим хүчний аюулгүй байдал: Бахрейн, Индонез
2. Ядуурлыг бууруулах: Бангладеш, Камбож, Вьетнам
3. Хөдөө аж ахуй: БНХАУ
4. Тээврийн сүлжээ, биотехнологи: Энэтхэг
5. Цахим боловсрол: Малайз

6. Стандарт хэмжил зүйн Азийн институт: Пакистан
 7. Жижиг дунд үйлдвэр: Сингапур
 8. Мэдээллийн технологи: БНСУ
 9. Эрчим хүч, ШУТ: Филиппин
 10. Санхүүгийн хамтын ажиллагаа: Тайланд
 11. Аялал жуулчлал: Тайланд, Камбож
 12. Хүний нөөцийн хөгжил: Вьетнам
 13. Байгаль орчны боловсрол, эрх зүйн орчинг бэхжүүлэх: Япон
- Эдгээр төслүүдээс Монгол Улс аялал жуулчлал, хөдөө аж ахуй, ядуурлыг бууруулах гэх мэт чиглэлд Монгол Улс төслийн хошуучлагчаар оролцох боломжтой.

Дүгнэж үзэхэд, нийт Ази тивийн болон бүс нутгийн хэмжээнд засгийн газрын болон засгийн газрын бус түвшинд өрнөж буй улс төр, эдийн засгийн үйл явцуудад аль болох идэвхтэй хамрагдаж, оролцохыг зорьж байдаг манай улсын хувьд эдүгээ Азийн нөлөө бүхий ихэнх улсууд төлөөлөгчөө оролцуулж, тодорхой ач холбогдол өгч байгаа АРФ, АСЕМ, АХАЯХ-ний үйл явцад идэвхтэй оролцохыг олон талт гадаад бодлогынхоо нэг тэргүүлэх чиглэл гэж үзэж байна. Мөн эдгээр форумаар дамжин хоёр талын харилцааг урагшлуулах ахиулах хангалттай боломж буйг байнга ашиглахыг чухалчилна.